



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/12

Мандалговь

**Хамгаалах байрны зарим үйлчилгээг
“Оюуны гэгээ” төрийн бус байгууллагаар
гүйцэтгүүлэх тухай**

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 18 дугаар зүйлийн 18.2.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 12 сарын 26-ны өдрийн А/330 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журам”-ын 5.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, хүүхдэд үзүүлэх холбон зуучлах, эргэх холбоотой ажиллах, өмгөөллийн туслалцаа үзүүлэх, хуулийн байгууллагад өгөх нотлох баримт бүрдүүлэх, гаднаас мэргэжилтэн урьж ажиллуулах үйл ажиллагааг “Оюуны гэгээ” ТББ-аар гэрээгээр гүйцэтгүүлсүгэй.

2. Үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах ажлын хэсгийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Шаардагдах зардалд 2 500 000 (Хоёр сая таван зуун мянга) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. “Оюуны гэгээ” төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэн, хяналт тавьж ажиллахыг Хүүхэд хамгаалал, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн, ажлын хэсгийн ахлагч (Ш.Эрдэнэсүвд), гишүүдэд үүрэг болгосугай.

5. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг Хүүхэд хамгаалал, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн, ажлын хэсгийн ахлагч (Ш.Эрдэнэсүвд)-д даалгасугай.

ДАРГА



Ц. ГАНЗОРИГ

481190030